ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баян-Уул сумын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: ДОА-2026/004/НА-СТА-ТТЗ**


| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Чойбалсан хот<br>2026 он | Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>Тэргүүлэх аудитор: Б.Болортуул<br>Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn<br>Аудитын менежер: Д.Нармандах<br>Утас: 7058-4204, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn<br>Аудитор: Ө.Сийлэгмаа<br>Утас: 7058-4207, Цахим хаяг: siilegmaau@audit.gov.mn |


*Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.*

# Агуулга


1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 3

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 5

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан ..... 6

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ..... 6

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 7

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 8

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 9

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ..... 9

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ..... 9

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ..... 9

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..... 10

3.4.1 Мөнгөн хөрөнгө ..... 10

3.4.2 Авлага ..... 11

3.4.3 Бараа материал ..... **Error! Bookmark not defined.**

3.4.4 Үндсэн хөрөнгө ..... **Error! Bookmark not defined.**

3.4.5 Засгийн газрын хувь оролцоо ..... **Error! Bookmark not defined.**

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... **Error! Bookmark not defined.**

3.5.1 Төсвийн төлөвлөлт ..... **Error! Bookmark not defined.**

3.5.2 Төсвийн гүйцэтгэл ..... **Error! Bookmark not defined.**

3.5.3 Нэмэлт төсөв ..... **Error! Bookmark not defined.**

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн ..... **Error! Bookmark not defined.**

4. АУДИТЫН ТАЙЛАН ..... **Error! Bookmark not defined.**

4.1 Ерөнхий зүйл ..... **Error! Bookmark not defined.**

4.2 Материаллаг байдал ..... **Error! Bookmark not defined.**

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... **Error! Bookmark not defined.**

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... **Error! Bookmark not defined.**

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд ..... **Error! Bookmark not defined.**

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... **Error! Bookmark not defined.**

4.5.1 Завсрын аудитын талаар ..... **Error! Bookmark not defined.**

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн ..... **Error! Bookmark not defined.**

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... **Error! Bookmark not defined.**

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 8

5.2 Зөвлөмж ..... 17

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ..... 97

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ОНХС | Орон нутгийн хөгжлийн сан |
| ЗДТГ | Засаг даргын тамгын газар |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн хурал |
| ТТЗ | Төсвийн төвлөрүүлэн захирагч |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| ОНЕО | Орон нутгийн ерөнхий орлого |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Баянтүмэнгийн гудамж, 9 дүгээр баг
Хэрлэн сум, Дорнод аймаг. 21000
Утас: 7058-4203

2026.03.25 № 427

танай__________-ны №__________-т

ДОРНОД АЙМГИЙН БАЯН УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА М.БАТТУЛГА ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Дорнод аймгийн Төсвийн төвлөрүүлэн захирагч Баян-Уул сумын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ. Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн нэгтгэсэн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

**Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 241.6 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу нийт дүнгээрээ материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Улзын хөгжил хоршоо ОНӨААТҮГ-ийн нягтлан бодох бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, журам, зааврын дагуу журналын бүртгэл, хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, ажил гүйлгээг зохих ёсоор хөтлөөгүй.

**Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна.

2126050237

**Бусад асуудлын хэсэг**

Баян-Уул сумын Засаг даргын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 89.7. хувьтай дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.БОЛОРТУУЛ

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Эхний үлдэгдэл | 2. Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **603,807,614.77** | **688,855,709.68** |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 356,492,280.66 | 465,318,642.57 |
| 33 | АВЛАГА | 72,011,822.60 | 40,186,955.60 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 175,303,511.51 | 183,350,111.51 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **8,330,767,263.73** | **9,399,003,669.94** |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 8,330,767,263.73 | 9,399,003,669.94 |
| 39200 | Биет хөрөнгө | 8,184,565,888.73 | 9,252,989,794.94 |
| 39300 | Биет бус хөрөнгө | 146,201,375.00 | 146,013,875.00 |
| 39301 | Програм хангамж | 1,500,000.00 | 1,500,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (515,625.00) | (703,125.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 145,217,000.00 | 145,217,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2** | **8,934,574,878.50** | **10,087,859,379.62** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **144,385,423.00** |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 144,385,423.00 |
| 41300 | Өглөг | - | 144,385,423.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 8,934,574,878.50 | 9,943,473,956.62 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 8,934,574,878.50 | 9,943,473,956.62 |
| 51100 | Засгийн газрын оруулсан капитал | 840,634,496.80 | 840,634,496.80 |
| 51200 | Хуримтлагдсан үр дүн | 7,918,523,530.49 | 8,927,422,608.61 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 175,416,851.21 | 175,416,851.21 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **8,934,574,878.50** | **10,087,859,379.62** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 1. Өмнөх он | 2. Тайлант он |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН** | **6,503,568,496.39** | **7,829,379,292.98** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,628,905,599.68 | 1,787,227,602.24 |
| 110 | Орлогын албан татвар | 1,386,893,024.88 | 1,563,115,760.91 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,425,374,193.06 | 1,603,115,760.91 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (38,481,168.18) | (40,000,000.00) |
| 110101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (38,481,168.18) | (40,000,000.00) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 165,785,479.79 | 169,152,783.33 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 76,227,095.01 | 54,959,058.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,190,186,254.21 | 6,042,151,690.74 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,190,186,254.21 | 2,321,536,557.89 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,684,476,642.50 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **II** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **5,106,101,515.10** | **6,514,545,616.41** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 5,106,101,515.10 | 6,514,545,616.41 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,736,740,853.61 | 3,945,745,967.06 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 951,876,329.50 | 1,132,249,266.70 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 126,530,498.33 | 147,040,374.23 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 724,392,890.44 | 768,770,208.21 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 101,749,455.80 | 72,819,420.00 |
| 2105 | Нормативт зардал | - | 480,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 35,920,384.00 | 38,936,900.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 22,295,600.00 | 16,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 22,295,600.00 | 16,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 13,481,889.00 | 916,903,172.30 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 760,493,806.54 | 852,546,625.62 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,369,360,661.49 | 2,568,799,649.35 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)** | **1,397,466,981.29** | **1,314,833,676.57** |
| V | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 915,612,706.77 | 305,934,598.45 |
| **VI** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)** | **481,854,274.52** | **1,008,899,078.12** |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код: | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө/өмч |
|---|---|---|---|
| **1** | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **8,460,022,603.94** | **8,460,022,603.94** |
| 2 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | (10,879,999.96) | (10,879,999.96) |
| 3 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,449,142,603.98 | 8,449,142,603.98 |
| 5 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 3,578,000.00 | 3,578,000.00 |
| 9 | Тайлант үеийн үр дүн | 481,854,274.52 | 481,854,274.52 |
| **10** | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **8,934,574,878.50** | **8,934,574,878.50** |
| **11** | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **8,934,574,878.50** | **8,934,574,878.50** |
| 13 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 8,934,574,878.50 | 8,934,574,878.50 |
| 19 | Тайлант үеийн үр дүн | 1,008,899,078.12 | 1,008,899,078.12 |
| **20** | **2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл** | **9,943,473,956.62** | **9,943,473,956.62** |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/мянган төгрөгөөр/

| Дансны код | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын31 | 2025 оны 12-р сарын31 |
|---|---|---|---|
| **I** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН** | **5,536,019,078.39** | **5,767,466,007.98** |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 1,628,905,599.68 | 1,787,227,602.24 |
| 110 | Орлогын албан татвар | 1,386,893,024.88 | 1,563,115,760.91 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 222,636,836.21 | 3,980,238,405.74 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 222,636,836.21 | 259,623,272.89 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,684,476,642.50 | - |
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **4,504,251,181.33** | **4,903,176,198.26** |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,504,251,181.33 | 4,903,176,198.26 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,134,890,519.84 | 2,334,976,548.91 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,369,360,661.49 | 2,568,199,649.35 |
| **III** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **1,031,767,897.06** | **864,289,809.72** |
| **V** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН** | **938,328,153.85** | **549,463,447.81** |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 938,328,153.85 | 549,463,447.81 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 938,328,153.85 | 549,463,447.81 |
| **VI** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **(938,328,153.85)** | **(549,463,447.81)** |
| **VIII** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **93,439,743.21** | **108,826,361.91** |
| 101 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 263,052,537.45 | 356,492,280.66 |
| 20 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 356,492,280.66 | 465,318,642.57 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэлийн тайлан |
|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 5,583,919.10 | 5,564,317.10 |
| 11 | Татварын орлого | 1,773,461.30 | 1,787,227.60 |
| 110 | Орлогын албан татвар | 1,542,636.00 | 1,563,115.70 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 1,582,636.00 | 1,603,115.70 |
| 1101 | Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт | (40,000.00) | (40,000.00) |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 158,860.00 | 169,152.70 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 71,965.30 | 54,959.10 |
| 12 | Татварын бус орлого | 3,810,457.80 | 3,777,089.50 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 58,952.00 | 131,080.20 |
| 122 | Тусламжийн орлого | 3,189,042.30 | 3,097,607.40 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 562,463.50 | 548,401.90 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,357,337.30 | 5,393,514.40 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,428,873.80 | 4,647,845.70 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,384,722.00 | 2,203,755.70 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,122,208.10 | 1,091,962.30 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 140,277.20 | 135,336.90 |

| | | | |
|---|---|---|---|
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 835,362.20 | 777,279.90 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 35,643.30 | 24,662.30 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 60,730.60 | 49,182.70 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 17,000.00 | 16,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 7,016.60 | 3,519.40 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 166,484.00 | 105,812.10 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 44,151.80 | 2,444,090.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 722,463.50 | 539,668.60 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 206,000.00 | 206,000.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 354,822.10 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 463,639.50 |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/мянган төгрөгөөр/

| Код | Тайлангийн үзүүлэлт | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **12,620.5** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **12,620.5** |
| **210** | **БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **12,481.5** |
| 210401 | Бичиг хэрэг | 861.0 |
| 210402 | Тээвэр шатахуун | 2,612.0 |
| 210502 | Хоол хүнс | 480.0 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8,528.5 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **139.0** |
| 2131123 | Төвлөрүүлсэн үлдэгдэл | 139.0 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **12,620.5** |
| 1311 | Нэмэлт  санхүүжилтийн орлого | 12,620.5 |

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 32.3 сая төгрөгийн зөрчил[1] илэрсэнд 1 зөвлөмж өгсөн.

Нийт хамрах хүрээний байгууллагуудаас илэрсэн алдаа, зөрчлөөс 241.6 сая төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон ерөнхий материаллаг байдлын түвшнээс давж, дангаараа буюу эсвэл нийтээрээ материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 5.2 Зөвлөмж

1. Төсвийн орлогын төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой

*Илрүүлэлт* Сумын нийт орлого 2,470.5 сая төгрөг болж 17.5 сая төгрөг буюу 0.7 хувиар давж биелсэн боловч  газрын төлбөрийн орлого 11.6 сая, дуудлага худалдааны орлого 12.7 сая, хөрөнгийн орлого 3.3 сая,  ойн нөөц ашигласны төлбөр 4.7 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

*<u>Зөвлөмж</u>*: Орлогыг нэр төрлөөр нь биелүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д заасны дагуу “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” заалтыг хэрэгжүүлж ажиллах. Зөвлөмжийн биелэлтийг 2026 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

<table>
<tr><th rowspan="3">Зөрчлийн товч утга</th><th colspan="2" rowspan="2">Нийт зөрчил</th><th colspan="10">Үүнээс</th></tr>
<tr><th colspan="2">Төлбөрийн акт</th><th colspan="2">Албан шаардлага</th><th colspan="2">Зөвлөмж</th><th colspan="2">Хариуцлага тооцуулах албан шаардлага</th><th colspan="2">Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал</th></tr>
<tr><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Дүн</th><th>Тоо</th><th>Албан тушаалтны тоо</th><th>Тоо</th><th>Дүн</th></tr>
<tr><td>Орлогын төлөвлөлт, гүйцэтгэл</td><td>1</td><td>32.3</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>32.3</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
<tr><td>Дүн</td><td>1</td><td>32.3</td><td></td><td></td><td></td><td></td><td>1</td><td>32.3</td><td></td><td></td><td></td><td></td></tr>
</table>